



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/129/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: Bayankhongor@audit.gov.mn</p> <p>Баянхонгор хот 2020 он</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат</p> <p>Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: А.Цээням</p> <p>Утас: 70444470 Цахим хаяг:</p> <p>Аудитор: Б.Бямбаа</p> <p>Утас: 88050763 Цахим хаяг: Cpa_bymba@yahoo.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.13. Шилэн дансны мэдээлэл	8
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
Менежментийн захидал	9
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	9
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	10
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	11
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	13
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	13

Аудитын гэрчилгээ



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2020.02.17 № *1/108*

танай _____ -ны № _____ -т

Г Аудитын гэрчилгээ Г

Г ӨЛЗИЙТ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Ө.ХАШБИЛЭГ ТАНАА Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

005020066



Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

Аудитын тайлан

2.1. Оршил

Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг сургуулийн захирал Ө.Хашбилэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.02.11-нээс 2020.02.14-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Хонгорын үр сад аудит ХХК-ны аудитор Б.Бямбаа хариуцаж хэрэгжүүлэв.

Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургууль 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Хонгорын үр сад аудит ХХК-ны газарт 2020.02.10-ны өдрийн 19 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “ Сайн багшаас сайн шавийг төрүүлж, хүүхдийн хүмжүүжилд эерэг чиг хандлагыг төлөвшүүлсэн сургууль хамт олон болно. ” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлэн ажиллаж байна.

Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:



- Хичээлийн шинэ байрыг сургалтын орчин үеийн агуулга, арга зүй технологит нийцүүлэн тохижуулах
- Сургалтын алба, мэргэжлийн зөвлөлөөр хамтран ажлын байран дээр мэргэжил, заах арга зүй, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх
- Хүүхдийн хүмүүжил, төлөвшил, хөгжлийн асуудлаар эцэг, эх, олон нийтийн байгууллагатай хамтран ажиллаж, боловсролын үйлчилгээнд тэгш хамруулсан олон нийтийн оролцоот сургууль болох
- Насан туршийн боловсролын үйлчилгээг хамран сургах тойргийн иргэдэд хүртээмжтэй хүргэх гэсэн эрхэм зорилтуудыг дэвшүүлсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургууль нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох ХХК-ны Acolous программ хангамж ашигладаг байна.

Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 28 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 3 дугаар улирлын байдлаарх үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг "Их" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1087839,5 мянган төгрөгөөс тооцон 21756,7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 21756,7 мянган төгрөгөөр тооцсон нь төлөвлөлтийн шатанд сонгосон суурь үзүүлэлтийг өөрчлөөгүйтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 42351,0 мянган төгрөгөөр буюу 0,8%-иар хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 55885,9 мянган төгрөгөөр тус тус өссөн, бараа материалын дансны үлдэгдэл 17523,9 мянган төгрөгөөр өссөн материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛАГА
/мянган төгрөг/ ӨӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0,00	0,00	
Авлага	0	0	0
Урьдчилгаа	0,00	0,00	0,00
Бараа материал	120388,6	137912,5	17523,9
Үндсэн хөрөнгө	1666570,7	1722456,6	55885,9
Хуримтлагдсан элэгдэл	-164728,2	-280489,1	-115760,9
Нийт хөрөнгө	1622231,0	1579880,0	-42351,0
Өр төлбөр	0,00	0,00	0,00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1622231	1579880,0	-42351,0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1622231	1579880,0	-42351,0

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 55885,9 мянган төгрөгөөр нэмэгдэж тайлант онд 80959,6 мянган төгрөгөөр нэмэгдсэн ба энэ нь БСШУЯамнаас 54268,4 мянган төгрөгний үнэ төлбөргүй тоног төхөөрөмж өгсөн, төсвийн хөрөнгөөр 26691,2 мянган төгрөгийн хөрөнгө авсныг орлогод бүрэн авсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 17523,9 мянган төгрөгөөр өссөн нь сурагчдын сургалтын хэрэглэгдэхүүн, эм, бусад хангамжийн материалын үлдэгдэл нэмэгдсэнээс гадна бусад хангамжийн материалын зардал 146903,0 мянган төгрөгийн материал ирсэн нь шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2019.06.13-ны өдрийн 69 тоот тогтоолоор ашиглалтын шаардлага хангахгүй болсон барилга 11213,1 мянган төгрөг, Өлзийт сумын ИТХТ-чдийн 2019.05.21-ны 21 тоот тогтоолоор 13860,6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассанаас шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл өмнөх онд байхгүй, тайлант хугацаанд нэмж өр үүсээгүй, Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэлд тайлант хугацаанд өөрчлөлт ороогүй байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 12 хөтөлбөрт зориулан 981306,3 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 981306,3 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 828672,7 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр, орон нутгийн төсвөөс 152633,6 мянга санхүүжүүлэхээр төлөвлөжээ.


Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 976450,3 мянган төгрөг буюу 99,5 хувьтай байгаа нь батлагдсан төсвийг 4855,9 мянган төгрөгөөр хэмнэж буцаан төвлөрүүлснээс шалтгаалсан байна.

Нэмэлт төсөв: Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж 3237,3 мянган төгрөг дөнгөнд орсныг олгосон байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 7 чиглэлээр 28 эрсдэлд нийт 28 горим сорил хэрэгжүүлжээ.

Аудитаар нийт 775,9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнд 775,9 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, биет бус хөрөнгийн ашиглалтыг сайжруулахтай холбоотой 1 зөвлөмж өглөө.



Аудитаар дараах 775,9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа зөрчилд төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

Цалингийн зардлыг анхан шатны баримтаас хөөн давтан тооцоолоход төсвийн менежерийн 2019 оны 03 сарын 11-ны өдрийн Б/16, 2019 оны 03 сарын 11-ны Б/17 тоот тушаалаар цалин бууруулах сахилгын шийтгэл ногдуулсан Б.Өлзийбаатар 478098 төгрөг, Л.Мягмарсүрэн 297889 төгрөгийг үр дүнгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох журам"-ын 4.3. " Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сургалтын байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил, үүргээ гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй багш, туслах багш, бусад албан хаагчид олгоно" гэсэн заалтыг зөрчсөн, аж ахуй нэгж байгууллагад бүртгэгдсэн ажил гүйлгээ буюу үйл явдал нь тухайн тайлант хугацаанд бодитой болж өнгөрсөн байх гэсэн тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

Аудитаар биет бус хөрөнгийн ашиглалттай холбоотой зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй

2.13. Шилэн дансны мэдээлэл

Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг байршуулсан байдал дараах байдалтай байна. Үүнд:

2019 оны мэдээлэл оруулсан байдал дараах байдалтай байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	8	1	2
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	2	2	
4	Сар бүр	3	36	34	2	
5	Тухай бүр	8	96	78	18	
	Нийт	27	151	126	23	2

Улирал бүр мэдээлдэг төсвийн гүйцэтгэлийн мэдээний 3 дугаар улирлын мэдээ, тухай бүр мэдээлэх "Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт"-ийн 8 дугаар сарын мэдээ, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохцуулах заасан мэдэгдлийн 8 дугаар сарын мэдээ зэрэг эдгээр 3 мэдээг санамсаргүйн улмаас хоцроосон байна. Мөн тухай бүр мэдээлэх таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг-ийн 1-9 дүгээр сарын мэдээ мэдээлэлийг 2,3,4,8 дугаар мэдээг 10 сард нэмэлт зааварчилгаа өгсний улмаас дахин засварлан өөрчлөлт оруулсны улмаас хоцроосон байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж байхгүй

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

"Зөрчилгүй" дүгнэлт

Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС-ын дагуу

материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	120,388,640.59	137,912,540.58
35	БАРАА МАТЕРИАЛ	120,388,640.59	137,912,540.58
351	Түүхий эд материал	77,263,062.80	87,080,362.80
35110	Тусгай зориулалттай материал	77,263,062.80	87,080,362.80
354	Хангамжийн материал	43,125,577.79	50,832,177.78
35410	Бичиг хэргийн материал	1,912,300.00	2,025,300.00
35420	Аж ахуйн материал	6,032,373.00	6,057,373.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	1,250,000.00
35450	Барилгын засварын материал	866,500.00	1,699,500.00
35460	Хүнсний материал	00.12	00.11
35470	Бусад хангамжийн материал	34,314,404.67	39,800,004.67
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,501,842,457.58	1,441,967,501.71
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,501,842,457.58	1,441,967,501.71
392	Биет хөрөнгө	1,469,880,457.58	1,410,005,501.71
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,364,877,800.00	1,353,664,656.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-100,930,968.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	24,500,000.00	28,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-15,857,142.72	-19,821,428.40
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	114,114,450.13	112,554,110.73
39206	Хуримтлагдсан элэгдэл	-83,143,879.78	-83,421,387.12
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	103,651,277.13	168,310,676.37
39208	Хуримтлагдсан элэгдэл	-65,227,277.18	-75,815,387.87
39214	Бусад үндсэн хөрөнгө	26,965,230.00	26,965,230.00
393	Биет бус хөрөнгө	31,962,000.00	31,962,000.00
39301	Програм хангамж	500,000.00	500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-500,000.00	-500,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	31,962,000.00	31,962,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,622,231,098.17	1,579,880,042.29
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	263,796.00	6,745,200.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	263,796.00	6,745,200.00
413	Өглөг	263,796.00	6,745,200.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	263,796.00	6,745,200.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,621,967,302.17	1,573,134,842.29
51	Засгийн газрын хувь оролцоо	1,621,967,302.17	1,573,134,842.29
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	821,578,958.90	821,578,958.90
51101	Өмч: - төрийн	821,578,958.90	821,578,958.90

Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

512	Хуримтлагдсан үр дүн	-63,052,460.85	-111,884,920.73
51210	Өмнөх үеийн үр дүн	-63,052,460.85	-63,052,460.85
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-48,832,459.88
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	863,440,804.12	863,440,804.12
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,622,231,098.17	1,579,880,042.29

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	860,380,771.80	1,039,007,061.24
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,658,268.00	54,463,461.24
120	Нийтлэг татварын бус орлого	21,658,268.00	54,463,461.24
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	21,658,268.00	54,463,461.24
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	21,533,268.00	54,463,461.24
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	13,253,303.80	155,870,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	825,469,200.00	828,672,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,639,369.80	3,237,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,639,369.80	3,237,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	152,633,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	152,633,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	891,558,260.96	1,075,326,342.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	891,558,260.96	1,075,326,342.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	821,028,713.16	1,043,587,666.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	443,290,005.00	577,043,912.00
210101	Үндсэн цалин	443,290,005.00	577,043,912.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,995,811.00	71,605,642.00
210201	Тэтгэврийн даатгал	34,583,659.00	52,575,104.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,784,028.00	4,777,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,186,859.00	3,764,193.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,400,547.00	934,945.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,040,718.00	9,554,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	147,196,647.00	148,090,460.00
210301	Гэрэл, цахилгаан	5,260,167.00	3,825,400.00
210302	Түлш, халаалт	141,454,480.00	143,583,960.00
210303	Цэвэр, бохир ус	482,000.00	681,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,895,952.81	11,566,741.00
210401	Бичиг хэрэг	1,324,500.00	1,978,200.00
210402	Тээвэр, шатахуун	1,732,500.01	5,532,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	831,893.00	915,941.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	104,000.00



Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,260,200.00	2,619,600.00
210408	Бараа материал акталсны зардал	7,618,859.80	416,500.00
2105	Нормативт зардал	76,580,795.89	84,992,623.01
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	558,900.00	782,695.00
210502	Хоол, хүнс	76,021,895.89	84,165,028.01
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	44,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,767,400.00	6,167,000.00
210604	Урсгал засвар	6,767,400.00	6,167,000.00
2107	Томилолт, зочны зардал	594,000.00	898,000.00
210702	Дотоод албан томилолт	594,000.00	898,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,117,200.00	852,850.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,117,200.00	221,850.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	631,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	76,590,901.46	142,370,438.22
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,187,850.00	4,438,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,980,350.00	9,611,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	70,422,701.46	128,321,438.22
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	70,529,547.80	31,738,676.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	68,101,098.00	26,882,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	23,054,400.00	22,310,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	20,564,064.00	3,237,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	540,800.00	1,335,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	38,340.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	38,340.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,241,080.00	4,817,636.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,241,080.00	4,817,636.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-31,177,489.16	-36,319,280.99
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	161,388,979.37	12,513,178.89
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	86,060,322.25	12,513,178.89
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-161,388,979.37	-12,513,178.89
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-192,566,468.53	-48,832,459.88

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	838,847,503.80	984,543,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	838,722,503.80	984,543,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	825,469,200.00	828,672,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,639,369.80	3,237,300.00

Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,639,369.80	3,237,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	152,633,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	152,633,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	838,847,503.80	984,543,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	838,847,503.80	984,543,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	768,317,956.00	952,904,924.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	447,278,216.00	577,043,912.00
210101	Үндсэн цалин	359,556,816.00	452,235,812.00
210102	Нэмэгдэл	62,435,400.00	80,841,600.00
210104	Урамшуулал	25,286,000.00	43,966,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,007,600.00	71,605,642.00
210201	Тэтгэврийн даатгал	34,671,700.00	52,575,104.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,334,100.00	4,777,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,467,200.00	3,764,193.00
210204	Ажилгүйдлийн даатгал	866,800.00	934,945.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,667,800.00	9,554,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	147,451,647.00	142,595,260.00
210301	Гэрэл, цахилгаан	5,515,167.00	3,825,400.00
210302	Түлш, халаалт	141,454,480.00	138,088,760.00
210303	Цэвэр, бохир ус	482,000.00	681,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,406,293.00	14,638,841.00
210401	Бичиг хэрэг	1,286,900.00	2,091,200.00
210402	Тээвэр, шатахуун	1,732,500.00	5,532,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	831,893.00	915,941.00
210404	Ном, хэвлэл	594,800.00	3,202,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	104,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,960,200.00	2,792,600.00
2105	Нормативт зардал	77,901,900.00	87,094,419.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	558,900.00	751,445.00
210502	Хоол, хүнс	75,758,100.00	84,460,074.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,584,900.00	1,882,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,922,400.00	38,192,000.00
210602	Тавилга	6,090,000.00	24,192,000.00
210604	Урсгал засвар	6,832,400.00	14,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	594,000.00	898,000.00
210702	Дотоод албан томилолт	594,000.00	898,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,479,200.00	852,850.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,479,200.00	452,850.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,276,700.00	19,984,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,132,600.00	8,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,144,100.00	11,984,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	70,529,547.80	31,638,676.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	68,101,098.00	26,782,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	23,054,400.00	22,310,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	20,564,064.00	3,237,300.00

Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	540,800.00	1,235,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	38,340.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	38,340.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,241,080.00	4,817,636.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,241,080.00	4,817,636.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	821,578,958.90	863,440,804.12	-63,052,460.85	00.00	1,621,967,302.17
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	821,578,958.90	863,440,804.12	-63,052,460.85	00.00	1,621,967,302.17
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	821,578,958.90	863,440,804.12	-63,052,460.85	00.00	1,621,967,302.17
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-48,832,459.88	00.00	-48,832,459.88
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	821,578,958.90	863,440,804.12	-111,884,920.73	00.00	1,573,134,842.29

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	766,789,400.00	756,702,517.00	981,306,300.00	976,450,324.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	766,789,400.00	756,702,517.00	981,306,300.00	976,450,324.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	675,264,200.00	665,239,431.00	957,593,900.00	952,904,924.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	416,826,400.00	410,523,135.00	577,165,000.00	577,043,912.00
210101	Үндсэн цалин	307,561,400.00	283,462,833.00	452,356,900.00	452,235,812.00
210102	Нэмэгдэл	85,917,200.00	103,794,680.00	80,841,600.00	80,841,600.00
210104	Урамшуулал	23,347,800.00	23,265,622.00	43,966,500.00	43,966,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,850,900.00	45,559,620.00	71,808,300.00	71,605,642.00
210201	Тэтгэврийн даатгал	29,177,800.00	29,141,324.00	52,699,900.00	52,575,104.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,334,600.00	3,283,699.00	4,777,000.00	4,777,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,168,300.00	4,104,423.00	3,821,800.00	3,764,193.00

Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210204	Ажилгүйдлийн даатгал	833,700.00	820,925.00	955,200.00	934,945.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,336,500.00	8,209,249.00	9,554,400.00	9,554,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	119,356,600.00	119,356,600.00	142,633,600.00	142,595,260.00
210301	Гэрэл, цахилгаан	3,614,300.00	3,496,828.00	3,825,400.00	3,825,400.00
210302	Түлш, халаалт	114,734,300.00	115,144,578.00	138,126,600.00	138,088,760.00
210303	Цэвэр, бохир ус	1,008,000.00	715,194.00	681,600.00	681,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,896,400.00	5,059,022.00	14,735,500.00	14,638,841.00
210401	Бичиг хэрэг	597,400.00	620,080.00	2,091,200.00	2,091,200.00
210402	Тээвэр, шатахуун	1,172,500.00	1,226,106.00	5,532,500.00	5,532,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,251,500.00	1,279,191.00	936,600.00	915,941.00
210404	Ном, хэвлэл	788,300.00	793,645.00	3,202,600.00	3,202,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	00.00	180,000.00	104,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,086,700.00	1,140,000.00	2,792,600.00	2,792,600.00
2105	Нормативт зардал	80,568,500.00	79,019,712.00	90,425,900.00	87,094,419.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	277,900.00	251,672.00	751,500.00	751,445.00
210502	Хоол, хүнс	79,023,700.00	78,076,540.00	87,791,500.00	84,460,074.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,266,900.00	691,500.00	1,882,900.00	1,882,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,657,700.00	1,616,400.00	38,192,000.00	38,192,000.00
210602	Тавилга	00.00	00.00	24,192,000.00	24,192,000.00
210604	Урсгал засвар	1,657,700.00	1,616,400.00	14,000,000.00	14,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	602,900.00	308,000.00	1,749,000.00	898,000.00
210702	Дотоод албан томилолт	602,900.00	308,000.00	1,749,000.00	898,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	564,800.00	567,200.00	900,600.00	852,850.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	564,800.00	567,200.00	500,600.00	452,850.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	00.00	400,000.00	400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4940000.00	3229742.00	19984000.00	19984000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,940,000.00	3,229,742.00	8,000,000.00	8,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	00.00	11,984,000.00	11,984,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	91525200.00	91463086.00	23712400.00	23545400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	91,525,200.00	91,463,086.00	23,712,400.00	23,545,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	17,220,500.00	17,220,500.00	22,469,000.00	22,310,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	403,900.00	341,800.00	1,243,400.00	1,235,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	766,489,400.00	756,702,517.00	981,306,300.00	976,450,324.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	766,189,400.00	756,402,517.00	828,672,700.00	823,855,064.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	00.00	828,672,700.00	823,855,064.00

Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	00.00	152,633,600.00	152,595,260.00
132001	Орон нутгийн төсвөөс	00.00	00.00	152,633,600.00	152,595,260.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих				
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	00.00	00.00	52.00	52.00
620001	Удирдах ажилтан	00.00	00.00	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	00.00	00.00	28.00	28.00
620003	Үйлчлэх ажилтан	00.00	00.00	23.00	23.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	00.00	00.00	490.00	508.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	00.00	00.00	490.00	508.00
630001	Төрийн өмчит ЕБС	00.00	00.00	490.00	508.00

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

НТ-2

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		3237300
21	УРСГАЛ ЗАРДАЛ		3237300
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		3237300
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		3237300
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		3237300
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН: АУДИТОР  БЯМБАА

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ

ХОЁРДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:
ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

